



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын
газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2023/93/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.open.audit.mn Булган аймаг 2024 он	Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn Аудитор: Г.Цэрэнлхам Утас: 7034-2495 Цахим хаяг: Tserenlkhamg@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 72

танай _____ ны № _____ т

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Ү.БЯМБАСҮРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Шатахууны зардалд түүврийн горим сорил хэрэгжүүлэхэд анхан шатны баримтгүй, шаардах хуудасгүй, жолоочийн тооцооны хуудасгүй 2,584.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан,
- Ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан 5 албан хаагчдад анх томилсон тушаалд цалингийн нэмэгдлээр, 1 албан хаагчдад 11-р сард сар бүр нийт 16,244.7 мянган төгрөгийг үнэлээгүй олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 382 дугаар тушаалаар баталсан "Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох тухай" журмын 4-р хавсралт, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчдад нөхөх төлбөр олгох тухай" журам, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

006020485

Асуудлыг онцолсон хэсэг

Газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгон, улсын хэмжээнд газар зүйн нэрийн тодруулалт хийх арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн байна.

Аудитын гол асуудал

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар авто машиныг хүлээлгэн өгч, албан хэрэгцээндээ хэрэглэж эхэлсэн боловч, аймгийн Засаг даргын 2024 оны А/10 дугаар захирамжаар орлого авч бүртгэлд тусгах шийдвэр гарсан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	60,924.2	164,806.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	518,155.7	493,421.6
	Нийт хөрөнгийн дүн	579,079.9	658,227.6
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	579,079.9	658,227.6
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	579,079.9	658,227.6
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	761,389.8	1,196,431.3
	Үйл ажиллагааны зардлын дүн	827,937.0	1,116,566.9
	Үйл ажиллагааны үр дүн	(66,547.3)	79,864.4
	Үйл ажиллагааны бус үр дүн	(3,878.3)	(716.7)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(70,425.6)	79,147.7
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	649,505.5	579,141.2
	Тайлант оны үр дүн	(70,425.6)	79,147.7
	Эцсийн үлдэгдэл	579,079.9	658,288.9
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	755,800.1	1,067,941.3
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	745,942.3	1,036,960.2
	Үйл ажиллагааны ЦМГ	9,857.8	30,981.1
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(9,857.8)	(30,981.1)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	873,603.6
	Урсгал зардал	-	873,603.6
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	873,603.6
	Улсын төсвөөс санхүүжих	-	806,830.4
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	66,773.1

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 30,294.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 3,684.8 мянган 2 төлбөрийн акт тогтоож, 16,244.7 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 15,440.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 30,294.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 17,875.4 мянган төгрөгөөр их тул Өөрчлөлттэй буюу хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Цалингийн зардлаас ажлаас чөлөөлөгдсөн хоёр албан хаагчид 2023 оны 1 дүгээр сард 1,100.8 мянган төгрөгийн цалин олгосон байна нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.3.5-д “*Бүртгэл тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн*” заалтыг үндэслэн орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

2. Шатахууны зардалд түүврийн горим сорил хэрэгжүүлэхэд анхан шатны баримтгүй, шаардах хуудасгүй, жолоочийн тооцооны хуудасгүй 2,584.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.3.5-д “*Бүртгэл тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн*” гэж заасныг үндэслэн орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

1. Ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан 5 албан хаагчдад анх томилсон тушаалд цалингийн нэмэгдлээр, 1 албан хаагчдад 11-р сард сар бүр үнэлээгүй нийт 16,244.7 мянган төгрөгийг олгосон нь Засгийн газрын 2019 оны 382 дугаар тушаалаар баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журам”-ын 4-р хавсралт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1.11-д “*Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх, үр нөлөөтэй гэж үзсэн*” заалтыг үндэслэн албан шаардлага өглөө.

2. 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2024 оны 01 дүгээр сарын 31-ны өдөр 01/93 тоот албан бичгээр хугацаа хоцроож Төрийн аудитын газарт ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэх заалтыг хэрэгжүүлээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.2-д “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтыг үндэслэн албан үүргээ биелүүлээгүйд хариуцлага тооцуулах албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” заалтыг үндэслэн аймгийн Засаг даргад албан шаардлага хүргүүллээ.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тушаал шийдвэргүйгээр 10,365.0 мянган төгрөгийн албан томилолтыг зарцуулсан нь Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчдад нөхөх төлбөр олгох тухай” журам, НББ-ын тухай хуулийн 4 дүгээр зүйл, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Албан томилолтоор ажиллах тухай бүрд шийдвэр гаргаж, НББ-ийн тухай хуулийн дагуу анхан шатны баримтаар ажил гүйлгээг хийж хэвших.

Илрүүлэлт: Албан томилолтын зардлаас олгосон 5,075.9 мянган төгрөгийн Солонгос улс явсан томилолтын шийдвэрийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод болгож мэдээлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)												
Алдааны товч утга	Нийт алдаа		НББ-ын бодлогыг буруу хэрэгжүүлсэнтэй холбоотой		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Залруулга хийгдээгүй.												
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		(мянган төгрөгөөр)									
			Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ажлаас чөлөөлөгдсөн хоёр албан хаагчид 2023 оны 1 дүгээр сард цалин олгосон.	1	1,100.8	1	1,100.8								
Анхан шатны баримтгүй, шаардах хуудасгүй, жолоочийн тооцооны хуудасгүй шатахуун зарцуулсан.	1	2,584.0	1	2,584.0								
Ур чадварын нэмэгдлийг 5 албан хаагчдад анх томилсон тушаалд цалингийн нэмэгдлээр олгосон, 1 албан хаагчдад 11-р сард үнэлээгүй сар бүр хавтгайруулан олгосон.	1	16,244.7			1	16,244.7						
2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2024 оны 01 дүгээр сарын 31-ны өдөр 01/93 тоот албан бичгээр	1				1	-						

хугацаа хоцроож Төрийн аудитын газарт ирүүлсэн.												
Тушаал шийдвэргүйгээр албан томилолтыг зарцуулсан, мөн томилолтын шатахууныг тээвэр шатахууны зардлаар тайлагнасан байна.	1	10,365.0					1	10,365.0				
Дүн	5	30,294.5	2	3,684.8	2	16,244.7	1	10,365.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг алдаатай мэдээлснээс нэгтгэл тайлангаар зөрүүтэй мэдээлсэн нь шилэн дансны тухай хуулийн зарчмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Гадаад томилолтыг тушаал шийдвэргүй олгосон, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод болгож мэдээлээгүй байна.	1	5,075.9					1	5,075.9
Дүн	1	5,075.9					1	5,075.9
Нийт дүн	1	5,075.9					1	5,075.9

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	1	1				1		
	ТШЗ-ийн дүн	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		